

ГАЗАРЗҮЙ


2007

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ


1. Хэнтийн нуруунаас эх авдаг, Хойд мөсөн далайн ай савын гол аль нь вэ? (1 оноо)
А. Тэс В. Завхан С. Ховд D. Улз E. Туул
2. Төвийн бүсийн тулгуур хотын нэг нь хот юм. (1 оноо)
А. Эрдэнэт В. Дархан С. Өндөрхаан
D. Улиастай E. Улаанбаатар
3. Доорх энергүүдийн аль нь цөмийн эрчим хүчний эх булаг вэ? (1 оноо)
А. Нарны энерги В. Салхины энерги С. Усны энерги
D. Байгалийн хий E. Аль нь ч биш
4. Дараах зурагт 3 тоогоор тектоникийн ямар хавтанг тэмдэглэсэн байна вэ? (1 оноо)

- A. Номхон далайн хавтан
- B. Африкийн хавтан
- C. Энэтхэг-Австралийн хавтан
- D. Антрактидийн хавтан
- E. Өмнөд Америкийн хавтан




5. 1:6 000 000 масштабтай зурагт А гол 4 см урт зурагдсан бол голын урт хэд вэ? (1 оноо)
А. 240 км В. 24 км С. 15 км D. 54 км E. 64 км
6. Үйлдвэрлэл бол хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд бүтээгдэхүүн үйлчилгээг хийх шаардлагатай төрөл бүрийн хүчин зүйлсийг нэгтгэсэн үйл явц юм. Үйлдвэрлэлийн анхдагч хүчин зүйлүүд нь гурав юм. (1 оноо)
А. Хүн, хөдөлмөр, тоног төхөөрөмж В. Хөдөлмөр, капитал, хүн
С. Хэрэгцээ, хөдөлмөр, хүн D. Газар, хөдөлмөр, капитал
E. Хэрэгцээ, хөдөлмөр, газар
7. Баруун Өмнөд Азийн экспортын гол бүтээгдэхүүнийг сонгоно уу. (1 оноо)
А. Үнэт мод В. Цахилгаан бараа
С. Машин тоног төхөөрөмж D. Газрын тос
E. Нүүрс
8. Дэлхийн цэнгэг усны нөөцийн 1/3-ийг дангаараа эзэлдэг, дэлхийн хамгийн гүн (1620м) нуурыг нэрлэнэ үү. (1 оноо)
А. Байгаль В. Титикака С. Гурон
D. Танганьик E. Эйр
9. Дэлхийн улсуудыг хөгжлийн төвшингөөр нь хэд хэдэн хэв шинжид хуваан авч үзэж болдог. Ийнхүү хуваахад доорх үзүүлэлтүүдээс алинийг нь гол болгон авч үзэж ирсэн бэ? (1 оноо)
А. Үйлдвэрлэлд хувийн хэвшлийнхний эзлэх хувь хэмжээ
B. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн
C. Улс төрийн тогтолцоо
D. Ажил эрхлэлт
E. Үндэсний нийт бүтээгдэхүүн
10. Цөлжилт үүсэхэд нөлөөлж буй байгалийн хүчин зүйлийг сонгоно уу. (1 оноо)
А. Цаг уурын таагүй нөхцөл В. Ой мод огтлох
С. Малын бэлчээрийн талхлалт D. Усыг зүй зохисгүй ашиглах
E. Үйлвэрлэлийн зохисгүй нөлөөлөл
11. Хүн ам нь олон үндэстнээс бүрэлдэн тогтсон улсыг сонгоно уу. (1 оноо)
А. Япон В. Герман С. АНУ
D. Бразил E. Польш

12. Дараах диаграммуудын аль нь дэлхийн гадаргын хуурай газар ба усны эзлэх талбайн харьцааг зөв харуулсан байна вэ? (1 оноо)



- A. 1 B. 2 C. 3 D. 4 E. 5
13. Галт тэргээр аялахад Улаанбаатараас баруун тийш хамгийн холдоо хаана хүрч болох вэ? (1 оноо)
 A. Баруун Хараа B. Сүхбаатар C. Багануур
 D. Дархан E. Эрдэнэт
14. Манай оронд нартай өдөр шонгийн модны сүүдрийн урт ямар байдаг вэ? (1 оноо)
 A. Сүүдрийн урт өдрийн туршид ижил хэмжээтэй байна
 B. Сүүдрийн урт нар мандахад хамгийн богино, нар жаргахад хамгийн урт байна
 C. Сүүдрийн урт нар мандахад хамгийн урт, нар жаргахад хамгийн богино байна
 D. Сүүдрийн урт нар хөөрөх тусам улам богино болно
 E. Сүүдрийн урт нар хөөрөх тусам улам урт болно
15. Манай орны тариалангийн талбайн 2/3-нь Орхон Сэлэнгийн сав газарт оршдогийн шалтгааныг тайлбарлана уу. (1 оноо)
 A. Тариаланд тохиромжтой хөрстэй
 B. Гадаргын усан хангамж сайн
 C. Үр тарианы үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа нь механикжсан
 D. Агротехникийн дэвшилттэй үйл ажиллагаатай
 E. Дээрх бүгд
16. Монгол оронд хамгийн их тархсан хөрс нь хөрс юм. (1 оноо)
 A. Говийн бор B. Нуга намгийн C. Хүрэн хөрс
 D. Давсархаг E. Уулын нугын
17. Хойд Европын орнуудаас аль улсад нь мебель эдлэл, цаас, целлюлозийн үйлдвэрлэл илүү хөгжсөн бэ? (1 оноо)
 A. Финлянд B. Дани C. Исланд
 D. Норвег E. Аль нь ч биш
18. Эдийн засгийн Хангайн бүсэд хамрагдахгүй аймгийг олоорой. (1 оноо)
 A. Хөвсгөл B. Орхон C. Завхан
 D. Баянхонгор E. Архангай
19. Дараах мэдээллийг уншаад, тохирох хариултыг сонгоно уу. тусгагаар зурагдсан зурагт голдоч зэргэдийн шугамууд нь тэгш өнцгөөр огтолсон шулуун байдлаар зурагддаг. (1 оноо)
 A. Конус B. Цилиндр C. Азимут
 D. Хөндлөн азимут E. Хуурамч конус
20. Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалыг боловсруулахдаа харгалзан үзсэн үзүүлэлт аль нь вэ? (1 оноо)
 A. Гадаад дотоод зах зээлд зохистой газарзүйн байрлал
 B. Аймаг орон нутгийн аж ахуй, соёлын уламжлалт харилцаа
 C. Байгалийн баялаг түүхий эдийн нөөц
 D. Засаг захиргааны нэгж, аж ахуйн салбар хоорондын хамтын ажиллагаа
 E. Дээрх бүгд
21. НҮБ-ын зорилгыг зөв томъёолсон хариултыг сонгоорой. (1 оноо)
 A. Хөрөнгө оруулалтыг чөлөөтэй болгох
 B. Цэрэг улс төрийн холбоог бэхжүүлэх
 C. Нэгдмэл удирдлага нэг парламенттай, бараа таваар, капитал үйлчилгээ, технологи, ажиллах хүчийг нэгээс нөгөөд чөлөөтэй шилжүүлж байх
 D. Олон улсын хэмжээнд энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх
 E. Газрын тос экспортлогч орнуудыг эгнээндээ багтаан олон улсын хэмжээнд газрын тосны монополийг хязгаарлах

22. Газрын зургийн агуулгыг илэрхийлэхдээ тохирох аргуудыг сонгон хэрэглэдэг.....ижил шугамын арга гэнэ. (2 оноо)
 А. Юмс үзэгдлийн тоон ялгаа өөрчлөлтийг төрөл бүрийн диаграммаар дүрсэлснийг
 В. Шилжилт хөдөлгөөнийг үзүүлснийг
 С. Геометрийн дүрс хэлбэр, үсэг тэмдэг, зураг зэргээр юмсын байршлыг харуулахыг
 D. Тухайн үзэгдэл юмсын адил утгатай цэгүүдийг холбож үзүүлэхийг
 E. Тухайн үзэгдэл юмсын өөр өөр утгатай цэгүүдийг холбож үзүүлэхийг
23. Африкийн орнуудаас хөгжлөөрөө тэргүүлэгч орныг сонгоно уу. (2 оноо)
 А. ӨАБНУ В. Намиб С. Чад
 D. Мали E. Кени
24. Чулуун мандлын бүрэлдэхүүнд 8 төрлийн химийн элемент зонхилдгоос 27.7%-ийг нь цахиур эзэлнэ. Үүнээс илүү хувийг эзэлдэг элемент нь аль вэ? (2 оноо)
 А. Төмөр В. Кальци С. Хүчилтөрөгч
 D. Калий E. Натри
25. Хойд Америк, Австралид англи хэл, Төв ба Өмнөд Америкт испани хэл, Бразилд португали хэл өргөн дэлгэрэхэд доорх хүчин зүйлүүдийн аль нь хамгийн ихээр нөлөөлсөн бэ? (2 оноо)
 А. Үйлдвэрлэлийн хөгжил В. Хүн амын нас хүйсийн бүтэц
 С. Шашин D. Хүн амын шилжилт
 E. Улс төрийн тогтолцоо
26. Угсаатан зүйн судалгаанд хамгийн тохиромжтой бүсийг сонгоно уу. (2 оноо)
 А. Зүүн В. Баруун С. Хангай
 D. Төв E. Улаанбаатар
27. Төвөөс зугтах хүч дэлхийн аль хэсэгт хамгийн их байдаг вэ? (2 оноо)
 А. Экватор дээр В. Матрын зам дээр С. Мэлхийн зам дээр
 D. Өргөрөг бүрт адил E. Туйл дээр
28. Зурагт дэлхийн тогтмол салхины бүслүүрүүдийг өнгөөр ялган үзүүлжээ. Зурагт пассат салхи салхилдаг бүслүүрийг ямар тоогоор дугаарласан байна вэ? (2 оноо)




- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5

29. Доорх газруудаас ОХУ-ын төмрийн хүдрийн гол нөөц ордыг сонгоно уу. (2 оноо)
 А. Аньшан В. Курск С. Дээд нуур
 D. Лабрадор E. Итобира
30. Агаарт тухайн үед бэлэн оршиж байгаа усны уурын хэмжээг гэнэ. (2 оноо)
 А. Харьцангуй чийг В. Үнэмлэхүй чийгийн багтаамж
 С. Үнэмлэхүй чийг D. Дутмаг чийг
 E. Шүүдэр цэг
31. Нүүрсний уурхайнуудаас хүчин чадлын хувьд хамгийн томд орох Багануурын ил уурхайн нүүрс нь Геологийн он тооллын хувьд хэдий үед хамрагдах вэ? (2 оноо)
 А. Силур В. Юра С. Перм
 D. Карбон E. Цэрд
32. Өвлийн улиралд сэрүүн бүсийн эх газар дээр үүссэн агаарын массын гол шинж нь байдаг. (2 оноо)
 А. Хуурай хүйтэн В. Хуурай халуун С. Халуун чийг ихтэй
 D. Хүйтэн чийг ихтэй E. Дээрх бүгд


33. Төмөр замаа 100% цахилгаанжуулсан улс дэлхийд ганцхан байдаг. Энэ аль улс вэ? (2 оноо)
 А. Герман В. Австри С. Франц
 D. Швейцари E. Англи
34. Энд хийн мандлын ямар давхаргын тухай мэдээлэл бичигдсэн байна вэ? давхаргад температур маш хурдан нэмэгддэг. Мөн нарны цацрагийн нөлөөгөөр агаарын хийн молекулууд иончлогдож атомаас зарим электрон салж байдаг. (2 оноо)
 А. Экзосфер В. Тропосфер С. Термосфер
 D. Стратосфер E. Мезосфер
35. Орхон, Ерөө үүлдрийн хонины шинж нь аль вэ? (2 оноо)
 А. Ууцан сүүлт В. Өөхөн сүүлт С. Каракул
 D. Нарийн, нарийвтар ноост E. Шируун ба шируүвтэр ноост
36. Байрзүйн зурагт бөмбөрцгийг голдочийн дагуу хэдэн градусаар багана болгон хуваадаг вэ? (2 оноо)
 А. 6 градусаар В. 22 градусаар С. 15 градусаар
 D. 4 градусаар E. 7,5 градусаар
37. Далайн урсгал гэдэг нь далайн гадарга орчмын усны хөндлөн чиглэлийн хөдөлгөөнийг хэлнэ. Доорх зурагт Гольфстримийн урсгалыг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (2 оноо)

- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5



38. Зөв тодорхойлолтыг сонгоно уу. Баарийн хэвтээ зөрүү гэдэг бол юм. (3 оноо)
 А. Изобарийн шугам
 B. Изобарийн шугамд перпендикуляр чиглэлийн 1000 км зай тутамд буурах агаарын даралтын хэмжээ
 C. Изобарийн шугамд перпендикуляр чиглэлийн 100 км зай тутамд буурах агаарын даралтын хэмжээ
 D. Их даралтын муж
 E. Бага даралтын муж
39. Хар тогоруу, цагаан тогоруу, цэн тогоруу зэрэг нэн ховор шувуудыг үзэхийн тулд шувуу судлахаар ирсэн аялагчид хаана очвол зохих вэ? (3 оноо)
 А. Лхачинвандад В. Хустай С. Булган гол
 D. Монгол дагуур E. Хөвсгөл
40. эндоген явц гэнэ. (3 оноо)
 А. Хүлэрийн үе
 B. Газрын гадаргад нөлөөлөх дэлхийн дотоод энергийн нөлөөлөл
 C. Манан үүсэх процесс
 D. Нарны гүнд явагдах цөмийн урвал
 E. Газрын гадаргад нөлөөлөх нарны энергийн нөлөөлөл
41. Дараах зурагт Нөмрөгийн дархан цаазат газрыг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (3 оноо)

- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5



42. Зүүн уртрагийн 90°-ын голдож, хойд өргөргийн 45°-ын зэргэд хоёр аль улсын нутагт огтлолцдог вэ? (3 оноо)

- A. Монгол B. Тува C. ОХУ D. Казахстан E. БНХАУ

43. Дараах уулуудыг зүүнээс баруун тийш орших дарааллаар нь зөв бичсэн хариултыг сонгоно уу. (4 оноо)


Уулууд:

- | | |
|--------------------|----------------------|
| /а/-Батхаан | A. б - а - г - д - в |
| /б/-Цамбагарав | B. г - а - д - б - в |
| /в/-Отгонтэнгэр | C. а - г - б - в - д |
| /г/-Асралт Хайрхан | D. а - б - д - в - г |
| /д/-Таванбогд | E. г - а - в - б - д |

44. Лакколит, батолит гэдгийг тайлбарлана уу. (4 оноо)

- A. Чулуулгийн физик өгөршилтийг хэлнэ
 B. Бялхмал галт уулшлийн үр дүнд бөмбөгөр, шовх оройтой галт уул үүсэх үйл явц
 C. Чулуулгийн химийн өгөршилт
 D. Галт уулын тайван бялхалтын үе, дэлбэрэлтийн үетэй ээлжлэн явагдах буюу холимог бялхалтын үйл явц
 E. Магма газрын гадарга дээр ил гарч ирэхгүй замдаа царцаж газрын гүнд шургамал чулуулгийн биет үүсэх үйл явц

45. Доорх байрзүйн зургийн асуултын тэмдэг тавьсан хуудасны номенклатурыг тодорхойлно уу. (4 оноо)



- A. L - 48
 B. K - 50
 C. N - 50 - B - a
 D. L - 50 - A
 E. M - 50 - A

46. Их хүчтэй циклон нь байгалийн онц аюултай үзэгдэл учраас зарим бүс нутгуудад ихээхэн хэмжээний хор хохирол учруулдаг. Ийм хүчтэй циклоныг Америкийн орнуудад торнадо, Азийн орнуудад тайфун гэж нэрлэх бөгөөд халуун, дулаан орнуудад үе үе үүсэн бүрэлддэг. Зөвхөн халуун, дулаан орнуудад хүчтэй циклон үүсдэг гол шалтгааныг сонгоно уу. (4 оноо)

- A. Далайн хүчтэй давалгаа
 B. Дулаан чийглэг агаарын эрчимтэй өргөгдөх үйл явц
 C. Төвөөс зугтах хүч экватор орчимд хамгийн их байдаг
 D. Дээрх газруудын альбедо хамгийн их
 E. Дээрх газруудад арктикийн фронт байдаг

ХОЁРДУГААР ХЭСЭГ


Анхааруулга

- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны 2-р хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл: эцсийн хариу 45 гарсан гэж үзвэл a-4, b-5 гэж бөглөнө.
- Цагийн бодлогын хариуг доорх хэлбэрээр бөглөнө. Жишээлбэл: өглөөний 6 цаг бол 06 буюу a-0, b-6, оройн 6 цаг бол 18 буюу a-1, b-8 гэж бөглөнө.

2.1. Тухайн үеийн агаарын температур нь -20°C. Чийгийн багтаамж нь 1.05 г/м³, үнэмлэхүй чийг 0.63 гр бол харьцангуй чийгийг ол. (4 оноо)

2.2. Хэрвээ зүүн уртрагийн 75°-д 10 цаг болж байгаа бол баруун уртрагийн 15°-д хэдэн цаг болж байх вэ? (4 оноо)

2.3. Агаарын бөмбөлөг 500 м өндөрт нисэж байлаа. Энэ үед газрын гадарга дээр агаарын температур 16°C байсан бол агаарын бөмбөлөг нисэж яваа өндөрт агаарын температур хэдэн градус байх вэ? (4 оноо)



2.4. Эдийн засгийн бүсийн тулгуур хотуудыг зөв харгалзуулаарай. (4 оноо)


- | | |
|----------------|-------------------------|
| A. Баруун | 1. Улаанбаатар |
| B. Хангай | 2. Ховд, Улиастай |
| C. Төв | 3. Чойбалсан, Өндөрхаан |
| D. Зүүн | 4. Дархан, Зуунмод |
| E. Улаанбаатар | 5. Эрдэнэт, Хархорин |

ХУВИЛБАР В

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ


- Хэнтийн нуруунаас эх авдаг, Номхон далайн ай савын гол аль нь вэ? (1 оноо)
 A. Дэлгэр B. Завхан C. Ховд D. Орхон E. Онон
- Хангайн бүсийн тулгуур хотын нэг нь хот юм. (1 оноо)
 A. Чойбалсан B. Зуунмод C. Эрдэнэт D. Ховд E. Улаанбаатар
- Доорх түлшний төрлүүдээс дулаан ялгаруулах чадвар багатайг нь сонгоно уу. (1 оноо)
 A. Аргал B. Хүлэр C. Нефть D. Хүрэн нүүрс E. Шатагч хий
- Дараах зурагт Берингийн хоолойг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (1 оноо)

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5




- 1:6 000 000 масштабтай зурагт А гол 7 см урт зурагдсан бол голын урт хэд вэ? (1 оноо)
 A. 42 км B. 420 км C. 67 км D. 53 км E. 43 км
- Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшинг харгалзан хотод зэрэглэл тогтоодог. Хотод улсын зэрэглэл тогтоох асуудлыг шийдвэрлэдэг. (1 оноо)
 A. Нийслэлийн засаг дарга B. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
 C. Монгол улсын ерөнхийлөгч D. Засгийн газар
 E. Улсын Их Хурал
- Доорх боомт хотуудын алианаас нь шууд Номхон далайд гарч болох вэ? (1 оноо)
 A. Нью-Йорк B. Буэнос Айрес C. Кейптаун
 D. Владивосток E. Лиссабон

Боловсролын Үнэлгээний Төв

8. Өмнөд Америкийн Андын нуруунд байдаг энэ нуурын гүн нь 304 м. Усны температур нь $+12^{\circ}\text{C}$ -аас дээш гардаггүй, дэлхийн хамгийн өндөрт оршдоогоороо онцлог энэхүү нуурыг нэрлэнэ үү. (1 оноо)
А. Гурон В. Дээд нуур С. Титикака
D. Эри E. Эйр
9. ОПЕК-ийн зорилго аль нь вэ? (1 оноо)
А. Олон улсын хэмжээнд энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх
B. Цэрэг улс төрийн холбоог бэхжүүлэх
C. Эдийн засаг улс төрийн холбоо бөгөөд нэг парламент, нэгдмэл удирдлагын дор хамтран ажиллах
D. Газрын тос экспортлогч орнуудыг эгнээндээ багтаан, монополийн үйл ажиллагааг хязгаарлах
E. Хөрөнгө оруулалтыг чөлөөтэй болгох
10. Цөлжилт үүсэхэд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлийг сонгоно уу. (1 оноо)
А. Ойг түймэрдэх В. Удаан хугацааны ган
C. Цаг уурын таагүй нөхцөл D. Ургамлын нөмрөгийн багасалт
E. Хөрс давсжих
11. Монгол хэл аль язгуур хэлний бүлэгт хамаарагддаг вэ? (1 оноо)
А. Уралын В. Алтайн C. Хятад-Төвд
D. Семит-Хамитийн E. Энэтхэг-Европын
12. Дараах диаграммыг ажиглаад юуг харуулсныг тодорхойлно уу. (1 оноо)
А. Агаар мандлын хийн бүрэлдэхүүнийг харуулсан
B. Амьд организмын биеийн бүтцэд агуулагдах элементүүдийг харуулсан
C. Усанд агуулагдах элементүүдийг харуулсан
D. Чулуун мандалд агуулагдах голлох элементүүдийг харуулсан
E. Доод мантид байх элементүүдийг харуулсан
- 
- | Element | Percentage |
|----------------|------------|
| O ₂ | 47% |
| Si | 28% |
| Al | 8% |
| Fe | 5% |
| Ca | 4% |
| K | 3% |
| Na | 3% |
| Mg | 2% |
13. “Улаанбаатар төмөр зам”-аар галт тэргээр аялахад Улаанбаатараас зүүн тийш хамгийн холдоо хаана хүрч болох вэ? (1 оноо)
А. Чойбалсан В. Багануур C. Замын-Үүд
D. Зүүнбаян E. Бор-Өндөр
14. Голын эхэнд болон адагт байгаа байшингуудын хувьд дараах тодорхойлолтуудаас аль нь хамгийн зөв бэ? (1 оноо)
А. Голын адагт байгаа байшин голын эхэнд байгаа байшингаас илүү өндөрт оршино
B. Голын эхэнд байгаа байшин голын адагт байгаа байшингаас илүү өндөрт оршино
C. Голын эхэнд байгаа байшингийн эргэн тойронд ургамал илүү өндөр ургана
D. Голын адагт байгаа байшингийн эргэн тойронд ургамал илүү өндөр ургана
E. Хоёр байшин хоёулаа ижил өндөрт оршино
15. Манай орны газар тариаланд зонхилдог үр тарианы ургамлыг сонгоно уу. (1 оноо)
А. Буудай В. Эрдэнэшиш C. Хөх тариа
D. Арвай E. Овьёос
16. Хамгийн их ялзмагтай хөрс бол хөрс юм. (1 оноо)
А. Давсархаг В. Хүрэн C. Говийн бор
D. Цөлийн гөлтгөнөт бор саарал E. Уулын хар шороон
17. Агломераци гэдгийг тайлбарлана уу. (1 оноо)
А. Дэлхийн улсууд нэг холбоонд нэгдэх үйл явц
B. Хотын төвлөрөл
C. Улс төрийн тогтолцоо өөрчлөгдөхтэй холбогдож улсууд дотроо задрах
D. Цагаачлах явдал
E. Монополийн эсрэг чиглэсэн үйл ажиллагаа
18. Эдийн засгийн баруун бүсэд хамрагдахгүй аймгийг олоорой. (1 оноо)
А. Ховд В. Баян Өлгий C. Увс
D. Баянхонгор E. Завхан
19. Дараах мэдээллийг уншаад тохирох хариултыг сонгоно уу. тусгагаар зурагдсан зурагт зэргэд нь тойрог, уртраг нь шулуун байдлаар зурагддаг. (1 оноо)
А. Азимут В. Конус C. Цилиндр
D. Хуурамч цилиндр E. Хуурамч конус
20. Монгол орныг эдийн засгийн 5 бүсэд хуваахаас өмнө хэдэн муж болгон хувааж төлөвлөлт судалгааны хүрээнд хэрэглэж ирсэн бэ? (1 оноо)

- А. Бүсчлэн хувааж байгаагүй
 С. Хойд, өмнөд бүсэд
 Е. Баруун, зүүн, төвийн бүсэд
- В. Баруун, зүүн бүсэд
 D. Хойд, өмнөд, баруун, зүүн 4 бүсэд
21. Аль нь хөгжингүй орны хүн амын шинж вэ? (1 оноо)
 А. Төрөлт бага, дундаж наслалт бага
 В. Төрөлт бага, нас баралт их
 С. Хүн амын өсөлт их, нас баралт бага
 D. Төрөлт нас баралт хоёулаа бага, дундаж наслалт өндөр, хүн амын өсөлт их биш
 E. Дундаж наслалт өндөр, хүн амын өсөлт их
22. Газрын зургийн агуулгыг илэрхийлэхдээ тохирох аргуудыг сонгон хэрэглэдэг. хөдөлгөөнт шугамын арга гэнэ. (2 оноо)
 А. Тухайн үзэгдэл юмсын адил утгатай цэгүүдийг холбож үзүүлэхийг /
 В. Геометрийн дүрс хэлбэр, үсэг тэмдэг, зураг зэргээр юмсын байршлыг харуулахыг
 С. Шилжилт хөдөлгөөнийг үзүүлснийг
 D. Юмс үзэгдлийн тоон ялгаа өөрчлөлтийг төрөл бүрийн диаграммаар дүрсэлснийг
 E. Тухайн үзэгдэл юмсын өөр өөр утгатай цэгүүдийг холбож үзүүлэхийг
23. Аливаа улс, төрийн байгууламж засаглалын хэлбэрээрээ ялгагддаг. Доорх улсуудаас хаант засаглалтай улс аль нь вэ? (2 оноо)
 А. Солонгос
 В. Орос
 С. Англи
 D. Америк
 E. Хятад
24. Хийн мандлын байнгын бүрэлдхүүний 20.9%-ийг хүчилтөрөгч эзэлнэ. Үүнээс илүү хувийг эзэлдэг элемент нь аль вэ? (2 оноо)
 А. Азот
 В. Аргон
 С. Озон
 D. Усны уур
 E. Неон
25. Гадаад худалдааны идэвхит баланстай улс гэж ямар улсыг хэлдэг вэ? (2 оноо)
 А. Ажиллах хүч солилцоход хязгаарлал тогтоодоггүй орон
 В. Экспорт нь импортоосоо давсан
 С. Импорт нь экспортоосоо давсан орон
 D. Импорт экспортын хэмжээ нь тэнцүү орон
 E. Аялал жуулчлалын салбар нь өндөр хөгжсөн орон
26. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ төмөр замаар дамжуулан Ази, Европын зах зээлд гаргах шаардлагатай бол тухайн үйлдвэрийн байршилд эдийн засгийн аль бүс илүү тохиромжтой вэ? (2 оноо)
 А. Зүүн
 В. Хангай
 С. Баруун
 D. Төв
 E. Дээрх бүгд
27. Төвөөс зугтах хүч дэлхийн аль хэсэгт хамгийн бага байдаг вэ? (2 оноо)
 А. Экватор дээр
 В. Өргөрөг бүрт адил
 С. Мэлхийн зам дээр
 D. Матрын зам дээр
 E. Туйл дээр
28. Зурагт дэлхийн тогтмол салхины бүслүүрүүдийг өнгөөр ялган үзүүлжээ. Зурагт салхигүйн бүслүүрийг ямар тоогоор дугаарласан байна вэ? (2 оноо)

- А. 1
 В. 2
 С. 3
 D. 4
 E. 5




29. Хар төмөрлөгийн үйлдвэрийн анхдагч түүхий эд болох төмрийн хүдрийг импортлогч орон нь аль вэ? (2 оноо)
 А. Орос
 В. Япон
 С. Австрали
 D. Канад
 E. Бразил
30. Тодорхой температуртай агаарын шингээж болох усны уурын дээд хэмжээг гэнэ. (2 оноо)
 А. Үнэмлэхүй чийгийн багтаамж
 В. Үнэмлэхүй чийг
 С. Харьцангуй чийг
 D. Дутмаг чийг
 E. Шүүдэр цэг
31. Говьсүмбэр аймгийн нутаг дахь Шивээ Овоогийн нүүрсний ил уурхай нь жилдээ 1 сая орчим тонн нүүрс олборлох хүчин чадалтай. Энэ уурхайн нүүрс нь Геологийн он тооллын хувьд хэдий үед хамрагдах вэ? (2 оноо)
 А. Карбон
 В. Юра
 С. Цэрд
 D. Перм
 E. Силур

Боловсролын Үнэлгээний Төв

32. Арктикийн агаарын масс нь шинжтэй байдаг. (2 оноо)
А. Зундаа дулаан чийглэг
В. Өвөл нь дулаан хуурай
С. Өвөл нь хүйтэн чийглэг
D. Өвөл зунгүй хүйтэн, хуурай, тунгалаг
E. Зундаа хүйтэн чийглэг
33. Ачаа эргэлт нь тээвэрлэсэн ачааны хэмжээ, явсан замаар тодорхойлогдох бөгөөд тонн километрээр илэрхийлэгдэнэ. Төмөр замын ачаа эргэлтээр дэлхийд тэргүүн байранд ордог улсыг нэрлэнэ үү. (2 оноо)
А. АНУ
В. ОХУ
С. Энэтхэг
D. БНХАУ
E. Канад
34. Энд хийн мандлын ямар давхрагын тухай мэдээлэл бичигдсэн байна вэ? давхаргад Озоны давхарга байх бөгөөд нийт агаарын 20 орчим хувь нь оршдог. (2 оноо)
А. Тропопауз
В. Тропосфер
С. Стратосфер
D. Экзосфер
E. Мезосфер
35. Доорх үхрүүдээс аль нь сүүний чиглэлийнх вэ? (2 оноо)
А. Сэлэнгэ
В. Сементаль
С. Монгол үхэр
D. Уянгын бор
E. Хайнаг
36. Байрзүйн зурагт бөмбөрцгийг зэргэдийн дагуу хэдэн градусаар эгнээ болгон хуваадаг вэ? (2 оноо)
А. 4 градусаар
В. 6 градусаар
С. 2 градусаар
D. 20 градусаар
E. 7.5 градусаар
37. Далайн урсгал гэдэг нь далайн гадарга орчмын усны хөндлөн чиглэлийн хөдөлгөөнийг хэлнэ. Доорх зурагт далайн хамгийн том урсгал болох Баруун зүгийн урсгалыг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (2 оноо)

- A. 1
B. 2
C. 3
D. 4
E. 5



38. гомотермийн үе гэнэ. (3 оноо)
А. Нуурын ус бүх давхрагтаа цельсийн 4°C-тай болох үеийг
В. Нуурын гадаргын усны температур -4°C болоод хүндрэн доош суухыг
С. Гадаргынхаасаа илүү дулаан, нягт багатай ус дээш хөөрөхийг
D. Нуурын гадаргын усны температур нь 4°C байхыг
E. Өвлийн цагт нуурын ус 0°C-тай болон хөлдөж эхлэхийг
39. Чулуужсан ой газрын гадаргад ил гарсан байгалийн ховор тогтоцыг жуулчдад сонирхуулахаар болвол хаана очих хэрэгтэй вэ? (3 оноо)
А. Ихнарт
В. Загийн усны хоолой
С. Эргэлийн зоо
D. Их газрын чулуу
E. Сүйхэнт
40. экзоген явц гэнэ. (3 оноо)
А. Хүлэрийн үеийг
В. Манан үүсэх процесс
С. Газрын гадаргын хотгор гүдгэр гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөхийг
D. Нарны гүнд явагдах цөмийн урвалыг
E. Газрын гадаргад нөлөөлөх дэлхийн дотоод энергийн нөлөөлөл

41. Дараах зурагт Ханхэнтийн дархан цаазат газрыг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (3 оноо)

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5



42. Монгол улстай шууд хиллэдэггүй боловч хамгийн ойр байдаг улсыг нэрлээрэй. (3 оноо)

- A. Тува
- B. Казахстан
- C. Шинжаан Уйгур
- D. Буриад
- E. Хойд Солонгос


43. Дараах уул нуруудыг зүүнээс баруун тийш орших дарааллаар нь зөв бичсэн хариултыг сонгоно уу. (4 оноо)

Уулууд:

- /а/-Шилийн Богд
- /б/-Хөгнө Хан
- /в/-Хан Хөхий
- /г/-Асралт Хайрхан
- /д/-Таванбогд
- A. б - а - г - д - в
- B. а - б - д - в - г
- C. г - а - в - б - д
- D. г - а - д - б - в
- E. а - г - б - в - д


44. Дараах 2 зурагт хотгор гүдгэрийн хэлбэрүүдийг харуулжээ. Грабен буюу Рифт хэлбэрийг ямар үсгээр тэмдэглэсэн байна вэ? (4 оноо)

- A. а
- B. б
- C. в
- D. г
- E. д



45. Доорх байрзүйн зургийн асуултын тэмдэгтэй хуудасны номенклатурыг тодорхойлно уу. (4 оноо)

- A. К-50
- B. L-50-A
- C. M-53
- D. M-47
- E. M-50-A



46. Антрактидын төв хэсэгт тэнгэр яагаад үүлгүй цэлмэг байдаг вэ? (4 оноо)


- A. Тропосфер нь харьцангуй нимгэн учраас
- B. Озоны давхрагын нөлөөллөөс
- C. Агаар нь хүйтэн, маш бага чийг агуулдагаас
- D. Мөсөн бүрхүүлтэй учраас
- E. Аль нь ч биш

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Анхааруулга

- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны 2-р хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл: эцсийн хариу 45 гарсан гэж үзвэл a-4, b-5 гэж бөглөнө.
- Цагийн бодлогын хариуг доорх хэлбэрээр бөглөнө. Жишээлбэл: өглөөний 6 цаг бол 06 буюу a-0, b-6, оройн 6 цаг бол 18 буюу a-1, b-8 гэж бөглөнө.

- 2.1. Тухайн үеийн агаарын температур нь -10°C . Чийгийн багтаамж 2.5 г/м^3 , харьцангуй чийг 80% байсан бол үнэмлэхүй чийгийг ол. (4 оноо)
- 2.2. Хэрвээ анхны голдож дээр 05 цаг болж байгаа бол аль голдож дээр 11 цаг болж байх вэ? (4 оноо)
- 2.3. Дараах зурагт үзүүлсэн Б цэг дээр агаарын температур хэдэн градус байх вэ? (4 оноо)




- 2.4. Дараах газарзүйн нэр томъёог тайлбартай нь зөв харгалзуулаарай. (4 оноо)
- | | |
|------------|--|
| a. Биомасс | 1. Америкт торнадо, Азид тайфун гэж нэрлэдэг |
| b. Циклон | 2. Газрын гадаргын нарны цацрагийг ойлгох чадвар |
| c. Промилл | 3. Амьд бодисын нийт хэмжээ |
| d. Альбедо | 4. Эх газрын тан |
| e. Шельф | 5. Далайн давсжилт |

ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Хангайн нуруунаас эх авдаг, Төв Азийн гадагш урсгалгүй ай савын гол аль нь вэ? (1 оноо)
- | | | |
|-----------|-----------|----------|
| A. Тамир | B. Чулуут | C. Орхон |
| D. Завхан | E. Идэр | |
2. Зүүн бүсийн тулгуур хотын нэг нь хот юм. (1 оноо)
- | | | |
|--------------|----------------|------------|
| A. Өндөрхаан | B. Дархан | C. Эрдэнэт |
| D. Улиастай | E. Улаанбаатар | |
3. Доорх түлшний төрлүүдээс дулаан ялгаруулах чадвар өндөртэйг нь сонгоно уу. (1 оноо)
- | | | |
|----------------|----------|-----------------|
| A. Занар | B. Нефть | C. Чулуун нүүрс |
| D. Хүрэн нүүрс | E. Аргал | |
4. Дараах зурагт Гвинейн буланг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (1 оноо)


- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5



15. Монгол улсын хот тосгоны эрхзүйн байдлын тухай хуулиар дараах үзүүлэлтүүдийн алийг нь харгалзан сууринг хот гэж тодорхойлж болох вэ? (1 оноо)
А. Хүн амын тоо
В. Үйлдвэр үйлчилгээний салбарт ажиллагсдын тоо
С. Хот бүрдүүлэгч дэд бүтэц
D. Орон нутгийн удирдлага
E. Дээрх бүгд
16. Хонхор газарт, хялбар уусдаг бодис элдэв давс хуримтлагдсаныг гэнэ. (1 оноо)
А. Марз
В. Лаав
С. Хунх
D. Морен
E. Магма
17. Конфедераци гэдгийг тайлбарлана уу. (1 оноо)
А. Нэг угсаа гаралтай үндэстнүүдийн нэгдсэн холбоо
В. Далайд гарцтай орнуудын нэгдмэл холбоо
С. Нефть импортлогч орнуудын ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулсан холбоо
D. Бие даасан улсууд өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хоорондоо нэгдэж байгуулсан холбоо
E. Аль нь ч биш
18. Эдийн засгийн Төвийн бүсэд хамрагдахгүй аймгийг олоорой. (1 оноо)
А. Дорноговь
В. Булган
С. Дархан-Уул
D. Дундговь
E. Төв
19. Дараах мэдээллийг уншаад, тохирох хариултыг сонгоно уу. тусгагаар зурагдсан зурагт зэргэд нь тойргийн нум хэлбэртэй, голдоч нь цацраг байдлаар зурагддаг. (1 оноо)
А. Конус
В. Азимут
С. Цилиндр
D. Хөндлөн азимут
E. Хуурамч цилиндр
20. Монгол улсын нийт хөдөлмөрийн нөөцийн 70.4% нь ажил үйлчилгээ эрхэлдэг. Хүн амын ямар хэсэг нь хөдөлмөрийн нөөцөд хамрагддаггүй вэ? (1 оноо)
А. 16 - 60 насны эрэгтэйчүүд
В. 16 - 55 насны эмэгтэйчүүд
С. Ажил эрхэлж буй өндөр настан
D. 16 нас хүрээгүй мөртлөө ажил эрхэлж буй хүүхэд
E. Тахир дутуу иргэд
21. Европын холбооны зорилгыг зөв томъёолсон хариултыг сонгоорой. (1 оноо)
А. Олон улсын хэмжээнд энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх
В. Нэгдмэл удирдлага нэг парламенттай, бараа таваар, капитал үйлчилгээ, технологи, ажиллах хүчийг нэгээс нөгөөд чөлөөтэй шилжүүлж байх
С. Цэрэг улс төрийн холбоог бэхжүүлэх
D. Хөрөнгө оруулалтыг чөлөөтэй болгох
E. Газрын тос экспортлогч орнуудыг эгнээндээ багтаан олон улсын хэмжээнд газрын тосны монополийг хязгаарлах
22. Газрын зургийн агуулгыг илэрхийлэхдээ тохирох аргуудыг сонгон хэрэглэдэг. картодиаграммын арга гэнэ. (2 оноо)
А. Тухайн үзэгдэл юмсын адил утгатай цэгүүдийг холбож үзүүлэхийг
В. Шилжилт хөдөлгөөнийг үзүүлсэнийг
С. Юмс үзэгдлийн тоон ялгаа өөрчлөлтийг төрөл бүрийн диаграммаар дүрсэлсэнийг
D. Геометрийн дүрс хэлбэр, үсэг тэмдэг, зураг зэргээр юмсын байршилыг харуулахыг
E. Тухайн үзэгдэл юмсын өөр өөр утгатай цэгүүдийг холбож үзүүлэхийг
23. Австрали нь олон улсын хөдөлмөрийн хуваарьт ямар бүтээгдхүүнээр оролцдог вэ? (2 оноо)
А. Цай
В. Хонины ноос, мах бэлтгэл
С. Цагаан будаа, олс
D. Кофе
E. Газрын тос, бэлэн хувцас
24. Монгол орны фосфоритын гол орд аль аймагт байдаг вэ? (2 оноо)
А. Баянхонгор
В. Төв
С. Өвөрхангай
D. Ховд
E. Хөвсгөл
25. Олон улсын хөдөлмөрийн газарзүйн хуваарь харилцан адилгүй байдгийн шалтгаан нь аль вэ? (2 оноо)
А. Газрын баялгийн тархалт
В. Байгаль цаг уур
С. Улс орнуудын аж ахуйн бүтэц онцлог давуу тал
D. Үйлдвэрлэх хүчний хөгжлийн ялгаатай түвшин
E. Дээрх бүгд


26. Эзэн Чингис хааны төрж өссөн нутагт сүм хийд бүхий аялал жуулчлалын цогцолбор барих болбол аль бүсийг сонгох вэ? (2 оноо)
 А. Зүүн В. Төв С. Баруун
 D. Хангайн E. Улаанбаатар
27. Хэвийн даралт гэж 45°-ын өргөрөгт, далайн түвшин дээрх агаарын даралт 1013.25 гПа, агаарын температур цельсийн градус байх үеийг хэлдэг. (2 оноо)
 А. 0°C В. -10°C С. 10°C D. -5°C E. 5°C
28. Зурагт дэлхийн тогтмол салхины бүслүүрүүдийг өнгөөр ялган үзүүлжээ. Зүүн зүгийн салхины бүслүүрийг ямар тоогоор дугаарласан байна вэ? (2 оноо)

- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5



29. Дэлхийд ачаа эргэлтийнхээ хэмжээгээр 1-рт ордог тээврийн төрөл нь аль вэ? (2 оноо)
 А. Дамжуулах хоолой В. Агаарын тээвэр С. Усан замын тээвэр
 D. Төмөр замын тээвэр E. Авто тээвэр
30. Агаарын үнэмлэхүй чийг ба чийгийн багтаамж хоёрын ялгаврыг гэнэ. (2 оноо)
 А. Харьцангуй чийг В. Үнэмлэхүй чийг С. Үнэмлэхүй чийгийн багтаамж
 D. Шүүдэр цэг E. Дутмаг чийг
31. Өмнөговь аймгийн нутаг дахь Тавантолгойн ордын коксжих нүүрс нь Геологийн он тооллын хувьд хэдий үед хамрагдах вэ? (2 оноо)
 А. Карбон В. Юра С. Цэрд D. Перм E. Силур
32. Сэрүүн бүсийн далай дээр бүрэлдсэн агаарын масс нь шинжтэй. (2 оноо)
 А. Их чийгтэй, өвөл нь дулаан, зун нь сэрүүн В. Зундаа халуун, хуурай
 С. Өвөл нь хуурай, хүйтэн D. Зун нь халуун чийг бага
 E. Өвөл нь хуурай, агаар нь тунгалаг
33. Аль улсад хурдан галт тэргийг Шинкансен гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
 А. Солонгос В. Япон С. Хятад
 D. Тайван E. Малайз
34. Энд хийн мандлын ямар давхрагын тухай мэдээлэл бичигдсэн байна вэ?..... буюу орчих мандалд нийт агаарын 80% оршиж, үүл үүсэх, цас бороо орох процесс зөвхөн энэ мандалд л явагддаг. (2 оноо)
 А. Термосфер В. Экзосфер С. Тропосфер
 D. Стратосфер E. Мезосфер
35. Доорх үүлдэрүүдээс аль нь сүүний чиглэлийн ямаа вэ? (2 оноо)
 А. Дон В. Говь-Гурвансайхан С. Эрчмийн нурууны хар
 D. Горный Алтай E. Аль нь ч биш
36. Байрзүйн зурагт туйл орчмын газрыг ямар үсгээр тэмдэглэдэг вэ? (2 оноо)
 А. А В. X С. Q D. Y E. Z
37. Далайн урсгал гэдэг нь далайн гадарга орчмын усны хөндлөн чиглэлийн хөдөлгөөнийг хэлнэ. Доорх зурагт Канарын хүйтэн урсгалыг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (2 оноо)


- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5





Боловсролын Үнэлгээний Төв

38. Магмын бүрэлдэхүүнд олон химийн элемент оролцох бөгөөд сууриллаг магма нь шинж чанартай байдаг. (3 оноо)
 А. Зууралдамтгай В. Ан цаваар түргэн нэвчдэг
 С. Амархан царцдаг D. Урсгал нь алгуур
 Е. Ан цаваар удаан нэвчдэг
39. Пржевальскийн адуу хэмээн нэрлэдэг тахийг үзэхийн тулд Голландын жуулчдын баг хаана очих хэрэгтэй вэ? (3 оноо)
 А. Ихнарт В. Хустай С. Эргэлийн зоо
 D. Онон Балжийн сав E. Монгол Дагуур
40. дрейф урсгал гэнэ. (3 оноо)
 А. Түрэлтийн урсгалыг
 В. Салхинд туугдаж үүссэн урсгалыг
 С. Далайн усны нягтаас үүдэлтэй урсгалыг
 D. Далайн гадаргын усны түвшинг жигдрүүлж байдаг урсгалыг
 E. Орчныхоо температуртай адил температуртай далайн урсгалыг
41. Дараах зурагт Хорьдол сарьдгийн дархан цаазат газрыг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (3 оноо)

- A. 1
 B. 2
 C. 3
 D. 4
 E. 5




42. Манай орны ойт хээрийн бүсэд газрын гадарга жилд 150 орчим хоног цасан бүрхүүлтэй байдаг. Цасан бүрхүүл удаан хугацаанд зузаан хэмжээтэй тогтох нь сөрөг нөлөөтэй боловч ямар сайн талтай вэ? (3 оноо)
 А. Гадаргыг чийгээр хангадаг В. Ахуйн хэрэглээнд ашигладаг
 С. Гадаргын дулаан хадгалдаг D. Хөрсийг гүн хөлдөлтөөс хамгаалдаг
 E. Дээрх бүгд
43. Дараах уул нуруудыг хойноос урагш орших дарааллаар нь зөв бичсэн хариултыг сонгоно уу. (4 оноо)
Уулууд:
 /а/-Асралт Хайрхан А. г - а - в - б - д
 /б/-Гурван Сайхан В. а - б - д - в - г
 /в/-Хорьдол Сарьдаг С. а - г - б - в - д
 /г/-Их богд D. д - в - а - г - б
 /д/-Монгол Шарын даваа E. д - в - а - б - г
44. Дараах 2 зурагт хотгор гүдгэрийн хэлбэрүүдийг харуулжээ. Хотгор гүдгэрийн Горст хэлбэрийг ямар үсгээр тэмдэглэсэн байна вэ? (4 оноо)



- A. а В. б С. в D. г E. д

45. Доорх байрзүйн зургийн асуултын тэмдэг тавьсан хуудасны номенклатурыг тодорхойлно уу. (4 оноо)

- A. L - 50 - A
- B. K - 50
- C. L - 49
- D. N - 50 - B - a
- E. M - 50 - A



46. Доорх дүгнэлтүүдийн алинд нь харьцангуй чийгийн хоногийн явцыг зөв тайлбарласан байна вэ? (4 оноо)


- A. Харьцангуй чийг температуртай урвуу хамааралтай
- B. Харьцангуй чийгийн хоногийн их утга нь нар гарахын өмнө байдаг
- C. Агаар дахь усны уурын хэмжээ тогтмол бус байдаг
- D. Хүйтэн агаар чийгээр амархан ханадаг
- E. Дээрх бүгд

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Анхааруулга

- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны 2-р хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл: эцсийн хариу 45 гарсан гэж үзвэл a-4, b-5 гэж бөглөнө.
- Цагийн бодлогын хариуг доорх хэлбэрээр бөглөнө. Жишээлбэл: өглөөний 6 цаг бол 06 буюу a-0, b-6, оройн 6 цаг бол 18 буюу a-1, b-8 гэж бөглөнө.

- 2.1. Температур -10°C , чийгийн багтаамж нь 2.5 г/м^3 , харьцангуй чийг нь 20% бол дутмаг чийгийг ол. (4 оноо)
- 2.2. Б.у. 30° -д 03 цаг болж байгаа бол з.у. 45° -д хэдэн цаг болж байх вэ? (4 оноо)
- 2.3. Агаарын бөмбөлөг 1500 м өндөрт нисэж байлаа. Бөмбөлгийн гадаргуу дээр агаарын температур 11°C байсан бол газрын гадарга дээр агаарын температур хэдэн градус байх вэ? (4 оноо)



2.4. Дараах түүхий эдүүдийг үйлдвэрүүдтэй нь зөв харгалзуулаарай. (4 оноо)

- | | |
|------------|----------------------------------|
| A. Жут | 1. Резин үйлдвэрлэлийн |
| B. Каучук | 2. Олс, загасны тор, нэхмэл |
| C. Нишингэ | 3. Барилгын болон модон эдлэлийн |
| D. Уран | 4. Сахарын үйлдвэр |
| E. Тик | 5. Цөмийн эрчим хүч |

2007 оны Газарзүйн хичээлийн даалгаврын түлхүүр

Нэгдүгээр хэсэг			
№	Хувилбар А	Хувилбар В	Хувилбар С
1	Е	Е	Д
2	В	С	А
3	Е	А	В
4	С	Е	С
5	А	В	Д
6	Д	Е	А
7	Д	Д	Е
8	А	С	А
9	В	Д	С
10	А	А	Е
11	С	В	А
12	А	Д	А
13	Е	С	Д
14	Д	В	Е
15	Е	А	Е
16	С	Е	А
17	А	В	Д
18	С	Д	В
19	В	А	А
20	Е	Е	Е
21	Д	Д	В
22	Д	С	С
23	А	С	В
24	С	А	Е
25	Д	В	Е
26	В	Д	А
27	А	Е	А
28	Д	Е	В
29	В	В	С
30	С	А	Е
31	Е	С	Д
32	А	Д	А
33	Д	В	В
34	С	С	С
35	Д	В	Е
36	А	А	Е
37	В	Д	А
38	С	А	В
39	Д	Е	В
40	В	С	В
41	В	В	Д
42	Е	В	Е

№	Хувилбар А	Хувилбар В	Хувилбар С
43	Е	Е	Д
44	Е	В	Е
45	А	Д	С
46	В	С	Е

Хоёрдугаар хэсэг												
	Хувилбар А				Хувилбар В				Хувилбар С			
	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4
a	6	0	1	2	2	9	7	3	2	0	2	2
b	0	4	3	5		0		1		8	0	1
c				4				5				4
d				3				2				5
e				1				4				3

